



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/614

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ковид-19-ын цар тахалтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулж буй “Нэг цэгийн үйлчилгээ”-ний бэлтгэл бэлэн байдлыг хангаж түргэвчилсэн тестийн шинжилгээний оношлуурын нөөц бүрдүүлэх санхүүжилтэд 60 000 000 төгрөг /жаран сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 60 000 000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн
А/614 дүгээр захирамжийн хавсралт

**“НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОШЛУУРЫН НӨӨЦ
БҮРДҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ**

№	Хүлээн авах байгууллагын нэр	Нийлүүлэх байгууллагын нэр	Бүтээгдэхүүн	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1.	Аймгийн ЭМГ	“Ивээлтгүн” ХХК №21/12 гэрээ	Түргэвчилсэн тестийн шинжилгээний оношлуур	5 000	12 000	60 000 000
	Нийт дүн			5 000	12 000	60 000 000

-оОо-